
МЭДЭЭ · 2026 оны 2-р сарын 6

# 2025 ОНД-УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ 45.3 ХУВИАР ӨСЖЭЭ




Улсын хэмжээнд 2025 онд нийт 4,831,351 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос 1.505.717 буюу 45.3 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн  93.2 хувь нь “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих”, 3.1 хувь нь “Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах”, 0.7 хувь нь “Автотээврийн тухай хууль зөрчих”, 0.4 хувийг “Хүний биед халдах”, 12,871 буюу 0.3 хувийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчил хамгийн их байна.


Зонхилон үйлдэгддэг дээрх зөрчлөөс “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих” зөрчил 4,503,272 бүртгэгдсэн нь өмнөх жилээс 56.2 хувиар, “Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил” 149,628 бүртгэгдсэн нь 31.5 хувиар өсөж, “Авто тээврийн тухай хууль зөрчих” зөрчил 35,111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 35.6 хувиар буурчээ.

Зөрчлийн улмаас иргэн, аж ахуй нэгж, байгууллагад 127,4 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 57,6 тэрбум төгрөг буюу 45.2 хувийг нөхөн төлүүлж, хохирлын нөхөн төлөлт өмнөх оноос 18.2 хувиар өсжээ.

Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 5,809 шийдвэрийг хүчингүй болгосноос 30.8 хувийг мөрдөх байгууллагад шилжүүлсэн, 20.1 хувьд нь шийтгэл оногдуулсан, 25 хувийг шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авахуулахаар шүүхэд шилжүүлсэн.

Мөн хууль зөрчиж шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулахаар 5,305 дүгнэлт *бичиж, шүүхээр* шийдвэрлүүлж, 9,713 хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн ажилласан.

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр шалгалт 427, судалгаа 203, танилцах ажил 103 удаа хийж, 16,668 зөрчил илрүүлэн, прокурорын шаардлага 229-г бичиж, 274 хүнд сахилгын арга хэмжээ авахуулж, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар аж ахуйн нэгж, байгууллагад 553 мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг тооцсон.




Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай, үр ашигтай болгох, зөрчлийн гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийн мэдээллийг нэгдмэл эх сурвалжид төвлөрүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан мэдээлэл солилцоог сайжруулах зорилтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ), “АйТиЗон” ХХК хамтран “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлж, ашиглаж байна.

---

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/625